



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 3)172

Хэрлэн сум

Ажлын гүйцэтгэгчийг сонгон  
шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих гудамж талбай цэвэрлэх бага оврын цахилгаан 2 машин авах, Хэрлэн сумын бkv цахилгаан дамжуулах шугамын трасс өөрчлөх ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Ажлын хэсгийн дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023  
. 231010470

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023  
231010470